

АУДИТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАР

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар нь Төсвийн байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайланд гэрээгээр аудит хийх хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулах тул аудитын зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

1. Энэхүү аудитын үйлчилгээ нь Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5-д заасны дагуу Төсвийн захирагчдын санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх шаардлагын дагуу зарлагдаж байгаа болно. Аудитын үйлчилгээний гэрээний нийт хугацаа нь 2018 оны 1 сарын 1-нээс 3 дугаар сарын 25 хүртэл үргэлжлэх болно.

2. Мэдүүлгээ ирүүлж буй аудитын хуулийн этгээд нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээлэл болон холбогдох бичиг баримтын баталгаат хуулбарыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх ба эдгээр нь Хураангуй жагсаалт бэлтгэх үндэслэл болно.

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ, аудит хийх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь тухайн жилд аудит хийх хуулийн цаглабар хугацаатай нийцсэн байх;
2. Аудитын компани нь хариуцлагын даатгалтай байх;
3. Аудитын компанийн захирал нь мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй байх;
4. Аудитын компани нь үндсэн 2-оос доошгүй мэргэшсэн нягтлан бодогчтой байх, өөр байгууллагад давхар ажил эрхлээгүй байх
5. Аудитын компанийн захирал болон мэргэшсэн нягтлан бодогчид нь мэргэжлийн ёс зүйн алдаа гаргаагүй талаар Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт (ММНБИ)-ийн тодорхойлолттой байх;
6. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн 21.1 дэх заалтыг зөрчөөгүй байх;
7. Төрийн аудитын байгууллагын захиалгаар сүүлийн 2 жил дараалан аудитын ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх, хэрэв ийм ажил гүйцэтгээгүй бол мөн хугацаанд улсын салбарт ижил төстэй ажил хийсэн туршлагатай байх.
8. Үндэсний аудитын газар болон бусад мэргэжлийн байгууллагаас хийгдсэн чанарын баталгаажуулалтын дүгнэлт.
9. Үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагааны болон санхүү, бүртгэлийн баримт материалыг хүлээн авах, хадгалах, аудит хийх шаардлага хангасан ажлын байртай байх

3. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор аудитын хуулийн этгээдүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 12 сарын 12-ны 18.00 цаг хүртэл ажлын цагаар авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2017 оны 12 сарын 13-ны өдрийн 10.00 цагаас өмнө ирүүлнэ үү.

***БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗДТГ 3 давхар 315 тоот,
Утас: 70442424***